БАТЛАВ
ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ө.БАТ-АМГАЛАН
2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

АХМАД НАСТАНД АМРАЛТ, СУВИЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сүхбаатар аймаг

Ерөнхий зүйл
Энэ техникийн тодорхойлолт нь Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасан хөнгөлөлттэй үнээр ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

Ажлын цар хүрээ
Уг үйлчилгээ нь Засгийн газрын тогтоолоор батлагдсан нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлтийн дагуу улсын хэмжээнд ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлнэ.

Тавигдах шаардлага

№	Нэр, төрөл	Тавигдах шаардлага
1	Багцтай эсэх	1-р багц: Ахмад настанд сувиллын үйлчилгээ үзүүлэх 2-р багц: Ахмад настанд амралтын үйлчилгээ үзүүлэх
2	Тусгай зөвшөөрөл	1-р багц Ахмад настанд үзүүлэх сувиллын үйлчилгээг аймаг нийслэлийн эрүүл мэндийн байгууллагаас сувиллын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллага байна. 2-р багц Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.2-т заасны дагуу амралтын газар нь амралтын газар, гэр буудал, жуулчны баазад тавигдах нийтлэг шаардлага хангасан тохирлын үнэлгээ хийлгэж Тохирлын гэрчилгээ авсан байна. Тусгай зөвшөөрөл болон тохирлын гэрчилгээний хугацаа дуусгавар болоогүй байх
3	Ерөнхий шаардлага	- Ахмад настанд хөнгөлөлттэй үнээр амралт сувиллын үзүүлэх албан хүсэлт. /Аль багцад оролцохоор тендэрийн баримт бичиг ирүүлж байгааг тодорхой бичих/ - Нэг байгууллага нэг л багцад оролцох эрхтэй - Амралт, сувиллын үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр ахмад настанд үйлчилгээ үзүүлэхэд хамтран

		ажиллахад татгалзах зүйлгүй тухай аймгийн ХХҮГ-ийн тодорхойлолт. - Амралт сувиллын үйлчилгээний шаардлага хангасан өөрийн болон түрээсийн байртай байх -гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар -Нэг ээлжинд хүлээн авах ахмад настны тоо, хүчин чадал / байр , гэр / мэдээлэл ирүүлэх . -Ахмад настан хүлээн авах хуваарь / өдөр, сар жилээр / ирүүлэх -Илчлэг ,калорийн шаардлага хангасан эрүүл хооллолтын хоолны цэс 7 хоногоор гарган ирүүлэх. Ахмад настанд зориулсан хөтөлбөр 7 хоногоор гарган ирүүлэх -Хоол үйлдвэрлэлийн үйлчилгээг мэргэжлийн тогоочоор гүйцэтгүүлэх. -Ахмад настныг мэдээллээр хангах боломжтой эсэх /зураг, радио, сонин сэтгүүл / мэдээлэл ирүүлэх. -Гадаад орчны тохижилтыг харуулсан фото зургууд зэрэг мэдээлэл ирүүлэх. -Багц 1-т Нөхөн сэргээлтийн кабинет, тоног төхөөрөмжтэй байх / зураг, түүний ашиглах талаар тайлбарыг хавсаргах/ -Багц 2-т Чөлөөт цаг өнгөрүүлэх танхимтай байна . -Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байх / үйлчлүүлэгчдийн ашиглах 00, душь, ванн фото зургаар ирүүлэх
4	Тусгай шаардлага	-Амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх байранд байнгын интернэт орчин бүрдүүлж, компьютер техник тоног төхөөрөмжөөр ханган, Халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/-д холбогдох боломжийг бүрдүүлсэн байна. -Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн дагуу ахмад настанд төлбөрийн баримт олгодог байх. - -Худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим систетд бүртгэлтэй байх

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ С.БАЛЖИННЯМ